

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР

2022 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2022 оны 05 дугаар сарын 04

Улаанбаатар хот

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийг баримтлан 2022 оны 04 дүгээр сарын 01-ээс 30-ны өдрийг дуустал үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллав.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:

1.1.1. Гадаадын иргэнд үзүүлсэн виз, визийн зөвшөөрлийн үйлчилгээ:

Тайлант хугацаанд 1679 гадаадын иргэнд визийн зөвшөөрөл олгож, үүнээс 1225 иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт, хилийн боомтод виз олгох 454 иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомт, бүсийн газруудад илгээлээ. (Хүснэгт 1)

Түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх хүсэлт гаргасан төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн 388 гадаадын иргэнд зохих ангиллын Монгол Улсын виз олгосон. Мөн 5 иргэнд гарах-орох цагаачийн мэдэгдэл олголоо. (Хүснэгт 1)

Хүснэгт 1

Визийн зөвшөөрөл		Виз	Оршин суух зөвшөөрөл			Түр ирэгч	
Хилийн чанадад	Хилийн боомтод		олгосон	сунгасан	хэлбэр, төрөл өөрчилсөн	хаягийн бүртгэл	байх хугацаа сунгалт
1225	454	388	686	1061	0	179	127
1679							

04 дүгээр сард нийт 473 аж ахуйн нэгж, байгууллагын 1494 гадаадын иргэний хүсэлтийг цахим (eimmigration.mn)-аар хүлээн авч, холбогдох хууль, журмын дагуу хянан, шийдвэрлэлээ.

“evisa.mn” цахим системээр нийт 27 улсын 611 иргэнд цахим виз олгож, 5 улсын 5 иргэний визийн хүсэлтэд татгалзсан.


1.1.2. Гадаадын иргэний бүртгэл, хяналт:

Эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг үндэслэн 686 гадаадын иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл олгож, 1061 иргэний оршин суух зөвшөөрлийн

хугацааг сунган, оршин суух зөвшөөрөлтэй 277 иргэний бүртгэлд хасалт хийлээ. (Хүснэгт 1)

Гадаадын иргэнийг уригч 33 аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийн дагуу 36 гадаадын иргэнд виз, бүртгэлийн талаарх мэдээлэл бүхий тодорхойлолт олгож, Монгол Улсад түр ирэгчээр ирсэн 179 гадаадын иргэнийг хаягийн бүртгэлд бүртгэсэн. Мөн Монгол Улсад 90 хүртэл хоногийн визтэй ирсэн болон визгүй зорчдог түр ирэгч гадаадын иргэдээс тус улсад байх хугацааг сунгуулах хүсэлтийг хянан 127 иргэний байх хугацааг 30 хүртэл хоногоор сунгасан. (Хүснэгт 1)

График 1



Дээрх тоон үзүүлэлтийг 2021 оны үзүүлэлттэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 75,8 хувь, оршин суух зөвшөөрөл олголт 76,8 хувиар тус тус өсөж, виз олголт 52,4 хувь, оршин суух зөвшөөрлийн сунгалт 13,8 хувиар тус тус буурчээ.

Цахим хэлбэртэй “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 1029 ширхэг шинээр хэвлэж, 703 үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунган, 25 үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ.

Оршин суух зөвшөөрөл авах болон оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт ирүүлсэн гадаадын 42 иргэний хүсэлтийг шийдвэрлэж, гадаадын 2 иргэнд регистрийн дугаар олгосон.

1.1.3. Зөвлөгөө, мэдээлэл:

Тайлант хугацаанд гадаадын иргэний Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл, түүний сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалт, визийн хугацааны сунгалтын асуудлаар нийт 3222 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

1800-1882 утас	Биечлэн	Фэйсбүүк хуудас чат	Автомат хариулагч	Имэйл	Нийт
2567	130	42	431	52	3222

Код мессеж үйлчилгээг 281 иргэнд хүргэж, 20 гадаадын иргэнд паспорт, 999 иргэнд оршин суух үнэмлэхийг буцаан олголоо.

Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх нэг цэгийн үйлчилгээний төвд биечлэн 464, утсаар 579 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч үйлчилгээ үзүүлжээ.

1.2. Иргэний харьяаллын чиглэлээр:

1.2.1. Иргэний харьяалал:

Харьяатын асуудлаар 13 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, 15 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагуудаас санал авах ажиллагааг явууллаа.

Хүснэгт 3

Хугацаа	Монгол Улсын харьяат болсон	Иргэний харьяаллыг сэргээн тогтоосон	Монгол Улсын харьяатаас гарсан	Хоёрдмол харьяалалтай иргэнийг бүртгэсэн
04 дүгээр сар	-	-	-	99
2022 он /өссөн дүнгээр/	1	-	-	159

Түүнчлэн 3 харьяалалгүй хүний хүсэлт, баримт бичиг, санал, дүгнэлтийг Ерөнхийлөгчид уламжлахаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн. (Хүснэгт 4)

“Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчтай ярилцлага хийх журам”-ын дагуу 04 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1 иргэнтэй ярилцлага хийсэн.

Монгол Улсын харьяатаас гарч бусад улс (Бүгд Найрамдах Солонгос Улсын 4, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 5, Шведийн Хаант Улсын 1, Япон улсын 1)-ын харьяат болохоор 11 иргэн хүсэлт, баримт бичиг шинээр ирүүлснийг хүлээн авсан байна.

Хүснэгт 4

Иргэний харьяаллын талаарх сарын мэдээ						
д/	Харьяалах улс	Хүлээн авсан хүсэлт	Түдгэлзүүлж буцаасан хүсэлт	Саналд илгээсэн	ЗГХЭГ-т хүргүүлсэн	ЕТГ-т хүргүүлсэн
Монгол Улсын харьяат болох						
1	Хятад Улс	1	-	3	-	-
2	Орос Улс	1	-	1	-	-
	нийт	2	-	4	-	-
Монгол Улсын харьяатаас гарах						
1	Монгол Улс	11	-	11	1	-
	нийт	11	-	11	1	-
Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох						
1	Харьяалалгүй хүн	-	-	-	-	3
	нийт	-	-	-	-	3

Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 52 улсын 4061 хоёрдмол харьяалалтай иргэн бүртгэлтэй байна. Тайлант хугацаанд хоёрдмол харьяалал үүсгэсэн 99 иргэнийг шинээр бүртгэжээ. (Хүснэгт 3)

1.2.2. Хүүхэд үрчлэлт:

04 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Монгол Улсаас гадаадын иргэн, гэр бүлд нийт 274 Монгол хүүхдийг үрчлүүлээд байна.

1.2.3. Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын бүртгэл, хяналт:

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн 1 байгууллагын хүсэлт, баримт бичгийг шинээр хүлээн авч, 1 байгууллагад Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүчингүй болгосон тухай тодорхойлолт олгосон.

Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтээ хугацаандаа гаргаагүй Бүгд Найрамдах Солонгос Улсад төвтэй “Нээлттэй эмч нарын нийгэмлэг” төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар (захиргааны ажилтан Л.Эрдэнэчимэг)-т 04 дүгээр сарын 27-ны өдөр сонсох ажиллагааг явууллаа.

1.3. Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:

1.3.1. Гадаадын иргэнд тавих хяналт шалгалт:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэн болон хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэлийн талаарх мэдээллийг 04 дүгээр сарын 11-ний өдрийн 01/687 дугаар, мөн сарын 25-ны өдрийн 01/785 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлсэн.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт 1 удаагийн хяналт шалгалтаар 17 гадаадын иргэний паспорт, түүнийг орлох баримт бичгийг шалгахад зөрчил илрээгүй.

Төлөвлөгөөт бус 34 удаагийн хяналт шалгалтыг 44 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 630 иргэнийг хамруулан зохион байгуулахад мөн зөрчил илрээгүй байна.

Хүснэгт 5

Торгуулсан гадаадын иргэн						
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл			Бүгд	Торгуулийн дүн
		16.2-1.2	16.2-1.3	16.2-3.3		
1	Филиппин			1	1	2000,000
2	Хятад	2			2	200,000
	Нийт	2		1	3	2200,000

Гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэх, шийдвэрлэх зорилгоор ажиллуулж буй 70133448 дугаар утсаар дамжуулан ирүүлсэн 1 гомдол, мэдээллийг хүлээн авч, 1 улсын 1 иргэний баримт бичигт үзлэг шалгалт явуулахад зөрчил илрээгүй тул гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, сайн дураар зөрчил гаргаснаа илчилсэн 3 иргэнд холбогдох гомдлыг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн.

Нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэх эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн болон визийн хугацааг хэтрүүлсэн нийт 2 улсын 3 гадаадын иргэнд Зөрчлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт зааснаар 2200,000

төгрөг (Хоёр сая хоёр зуун мянган)-ийн торгох шийтгэл оногдууллаа. (Хүснэгт 5, 6)

Хүснэгт 6

Зөрчлийн мэдээ (тухайн сард)							
Хувь хүнээр		Уригч байгууллагаар			Уригч хувь хүнээр		
Иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч байгууллага	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч иргэн	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/
3	2200,000	0	0	-	-	-	-
Гадаадын иргэн							
Хуулийн үндэслэл	Шалтгаан				Торгуулийн хэмжээ (төгрөг)	Гадаадын иргэний тоо	
Зөрчлийн тухай хууль 16.2-1.2	нутаг дэвсгэрт оршин суух үнэмлэхийг эзэмших, ашиглах, хадгалах журам зөрчсөн				200,000	2	
Зөрчлийн тухай хууль 16.2-3.3	визийн хугацааг хэтрүүлсэн бол хэтрүүлсэн хоног тутам арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно				2000,000	1	
					2200,000	3	

1.3.2. Хориг арга хэмжээ:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.11, 37.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн 2 улсын 3 иргэнийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар албадан гаргахаар шийдвэрлэлээ. (Хүснэгт 7)

Хүснэгт 7

Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэний мэдээ (тухайн сард)				
д/д	Харьяалах улс	Зүйлчлэл		Нийт
		37.1.11	37.1.12	
1	Вьетнам	2		2
2	Филиппин		1	1
	Бүгд	2	1	3


Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.7.3 дахь заалтыг үндэслэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 2 иргэнийг байгууллагын даргын 1 удаагийн тушаалаар Монгол Улсаас албадан гаргах тухай шийдвэрийг хугацаанаас өмнө цуцалсан.

Мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1, 34.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлсэн Бүгд Найрамдах Солонгос Улс 2, Оросын Холбооны Улсын 1 иргэнийг байгууллагын даргын нийт 3 удаагийн тушаалаар Монгол Улсын хилээр гарах эрхийг тус тус сэргээлээ.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан үндэслэлээр Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 1 удаагийн захирамжаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1 иргэнийг саатуулж, мөн шүүгчийн 1 удаагийн захирамжаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 1 иргэний саатуулсан хугацааг 30 хоногоор сунгасан байна.

Хойд бүс дэх газар виз, визийн зөвшөөрөлгүй ирсэн 8 улсын 29 иргэн, Баян-Өлгий аймаг дахь хэлтэс 2 улсын 3 иргэнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэлгүй буцаажээ.

График 2



04 дүгээр сарын тоон үзүүлэлтийг 2021 оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 3,2 дахин, зөрчил гаргасан уригч иргэн 2 дахин, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 55,6 хувь, саатуулсан гадаадын иргэн 33,3 хувиар тус тус өсөж, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 83,3 хувиар буурсан байна.

ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

2.1.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан:

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого” баталсантай холбогдуулан төрийн бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын үйл ажиллагаанд холбогдох “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 04 дүгээр сарын 12-ны өдөр баталлаа.

Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (erp.e-mongolia)-ийг хэрэглээнд нэвтрүүлэхэд үүсэж буй зарим үйлдэлтэй холбоотой доголдлыг завсарлуулах тухай албан бичгийг 04 дүгээр сарын 29-ний өдрийн 03/820 дугаар албан бичгээр “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газарт хүргүүлсэн.

Байгууллагын 04 дүгээр сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 06-ны өдөр баталж, 03 дугаар сарын тайланг боловсруулж, тоон мэдээг инфографик хэлбэрээр мөн

сарын 04-ний өдрийн 01/628 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 03 дугаар сарын 21-ний өдрийн Шуурхай хуралдаанаас ирүүлсэн үүрэг 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/678 дугаар албан бичгээр болон цахимаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын Шуурхай хуралдаанаас ирүүлсэн үүрэг даалгаврын 1 дүгээр улирлын биелэлтэд үнэлгээ хийлгэн, 04 дүгээр сарын 08-ны өдрийн 01/679 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээ.

2.1.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөц, сургалт:

Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн нэгжтэй хамтран хэрэгжүүлэх “Стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага”, Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь” дэд төслийн нээлтийн арга хэмжээнд байгууллагын удирдах албан тушаалтнууд оролцож, “Хамтран ажиллах төлөвлөгөө”-г Төрийн албаны зөвлөлийн дарга, байгууллагын дарга нар баталгаажууллаа.

Мөн тус төслийн нэгжтэй хамтран “Стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага”, Ёс зүйн зөвлөлийг бэхжүүлэх нь” дэд төслийн танилцуулгыг 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулж, нийт 161 албан хаагчийг, байгууллагад шинээр томилогдсон албан хаагчдын зарчимч, шударга байдлыг нэмэгдүүлэх төрийн албаны үнэт зүйлсэд суурилсан ёс зүйн чиг баримжааг бүтээхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан сургалтад 25 албан хаагчийг тус тус хамруулжээ.

2 албан тушаалд сул орон тооны сонгон шалгаруулалтын зарыг Төрийн албаны зөвлөлийн цахим системд байршуулсан.

Албан хаагчдын 1 дүгээр улирлын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг үндэслэн төв, төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох тухай 04 дүгээр сарын 07-ны өдрийн Б/92, Б/93 дугаар тушаалыг тус тус баталж, мөн 19-ний өдрийн Б/109 дүгээр тушаалаар орон нутаг дахь нэгжийн 2 албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг шинэчлэн тогтоолоо.

“Үндсэн хууль ба нийгмийн хамаарал, Хууль зүйн хэрэглээ” сэдэвт сургалтыг 04 дүгээр сарын 15, 22-ны өдрүүдэд, “Монгол бичиг”-ийн анхан, дунд шатны танхимын сургалтыг 05-аас 28-ны өдрийн хооронд, Англи хэлний дунд, гүнзгий шатны сургалтыг 27-ны өдрөөс эхлэн тус тус зохион байгуулж, 197 албан хаагчийг хамруулсан.

Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, үйлчилгээ, мэдээ, мэдээллийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран үйлчлүүлэгчдэд шуурхай хүргэх зорилгоор зарим албан хаагчдыг лавлах утасны оператороор бэлтгэх сургалтыг 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн зохион байгуулж, орон нутаг дахь нэгжийн 5 албан хаагч хамрагдаж байна.

Тайваний Боловсролын Яамны Хятад хэлний тэтгэлэг болон Бүгд Найрамдах Энэтхэг Улсын ЭСЯ-аас зохион байгуулах мэдээллийн технологи, англи хэлний богино хугацааны сургалтад хамрагдах албан хаагчийн мэдээллийг бэлтгэлээ.

Албан хаагчдын сэтгэл ханамж, стрессийн түвшин тогтоох 52 асуулт бүхий судалгааны асуумж хөрвүүлэн, боловсруулж, уг судалгаанд нийт 213 албан хаагчийг оролцуулан дүнг нэгтгэсэн.

2.1.3. Олон нийт, хэвлэл мэдээлэл:

Тайлант хугацаанд байгууллагын цахим сайтад үйл ажиллагаатай холбоотой 9, цахим сүлжээнд 12 мэдээ, мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 55 хэвлэл мэдээллийн хэрэгсэл (6 телевиз, 3 сонин, 45 сайт)-ээр сурталчилсан.

Байгууллагын цахим хуудас (фейсбүүк, твийтэр), elmmigration аппликэйшнд баяжилтыг хийж, байгууллагын үйл ажиллагаа болон үйлчилгээ авахтай холбоотой мэдээллийг тухай бүр тогтмол байршуулж байна.

“ОХУ-ын улсын иргэд олноор орж иржээ” гэх мэдээлэл нийгмийн сүлжээнд цацагдсантай холбогдуулан Монгол Улсад оршин сууж буй Оросын Холбооны Улсын иргэдийн тоон мэдээллийг 04 дүгээр сарын 25-ны өдөр eguur.mn, SBN, TV6 телевиз, байгууллагын цахим үйлчилгээтэй холбоотой мэдээллийг C Channel телевизэд тус тус бэлтгэн хүргүүлээ.

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг танилцуулсан видео шторк бэлтгэн, 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/658 дугаар албан бичгээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэв.

2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

2.2.1. Хууль, эрх зүй:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг даган гарах журам, эрх зүйн актын төсөл, “Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн ажиллах журам” болон “Хязгаарлалттай мэдээллийг өгсөн, дамжуулсан тохиолдолд мэдээллийн эзэнд мэдэгдэл хүргүүлэх, ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх журам”-ын төсөл, “Гадаадын иргэнд хүүхэд үрчлэх журам”-ын төсөлд саналуудыг 04 дүгээр сарын 01/723, 01/765, 01/771, 01/772 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүлсэн.

2.2.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа:

Байгууллагын дарга Бүгд Найрамдах Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдыг 04 дүгээр сарын 06-ны өдөр, Америкийн Нэгдсэн Улсын Консулын хэлтсийн даргыг 19-ний өдөр тус тус хүлээн авч харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг аюулаас хамгаалах яамны намын дарга бөгөөд тэргүүн дэд сайдтай 04 дүгээр сарын 26-ны өдөр хоёр улсын хууль сахиулах байгууллагын хамтын ажиллагааг эрчимжүүлэх талаар санал солилцсон хамтарсан хөтөлбөрийн арга хэмжээнд байгууллагын холбогдох албан тушаалтнууд оролцлоо.

Байгууллагын төлөөлөл Америкийн Нэгдсэн Улсад айлчлах тухай хүсэлтийг 04 дүгээр сарын 27-ны өдрийн 01/800 дугаар албан бичгээр тус улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдад хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Нийгмийг хамгаалах яам хооронд зохион байгуулах арга хэмжээний танилцуулгад тусгах мэдээллийн саналыг 04 дүгээр сарын 13-ны өдрийн 01/709, Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх хамтарсан ажлын хэсгийн анхдугаар хуралдаанд хэлэлцүүлэх асуудалд тусгах саналыг мөн сарын 29-ний өдрийн 01/817 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус хүргүүллээ.

2.3.2. Дотоод хяналт:

Иргэний харьяаллын газрын дарга, Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга, Санхүүгийн хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэй “Ажлын хэсэг” Баруун бүс дэх газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2020, 2021 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн болон төлөвлөгөөт хяналт шалгалт, 2022 оны 1 дүгээр улирлын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг 04 дүгээр сарын 14-аас 18-ны өдрийн хооронд тус тус гүйцэтгэлээ.

“Олон Улсын хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр”-ийг тохиолдуулан “Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, үүрэг хүлээгчдийн анхаарах асуудал” сэдэвт сургалтыг 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулж, 92 албан хаагчийг танхимаар болон цахимаар хамрууллаа.

2.4. Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын чиглэлээр:

2.4.1. Архив, албан хэрэг хөтлөлт:

Байгууллагын 2022 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 04 дүгээр сарын 22-ны өдөр батлав.

2021 оны баримт хүлээн авах хуваарийн дагуу зохион байгуулалтын нэгжүүдээс нийт 328 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт хийлээ.

Хууль тогтоомжийн хүрээнд 13 албан хаагчид 123 хадгаламжийн нэгжийг түр олгосон баримтын бүртгэлээр олгож, 40 албан хаагчид 512 хуудас баримтыг “Хуулбар үнэн” тэмдгээр баталгаажуулж, бүртгэл хөтөлсөн.

Тайлант хугацаанд байгууллагын даргаас үндсэн үйл ажиллагаатай холбоотой тушаал 8, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой тушаал 30 буюу нийт 38 тушаал баталсныг цахим хэлбэрт шилжүүлж, архив албан хэрэг хөтлөлтийн программд бүртгэн, хариуцсан албан хаагчдаар үүргийн биелэлтийг хангуулан ажилласан.

Байгууллагад ирүүлсэн нийт 198 албан бичиг (*хариутай 114*)-ийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, нийт 182 албан бичгийг гадагш илгээсэн ба хяналтад 28 албан бичиг байна.

2.4.2. Өргөдөл, гомдол:

Тайлант хугацаанд аж ахуйн нэгж, иргэн, албан хаагчаас төв байгууллагад 35 (*иргэнээс 17, албан хаагчаас 18*), боомт, орон нутаг дахь нэгжид 34 (*иргэнээс 7, албан хаагчаас 27*) өргөдөл буюу нийт 69 өргөдөл, 1 гомдол ирүүлснийг хүлээн

авч, 57 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэн, 12 өргөдөл, 1 гомдол шийдвэрлэлтийн шатанд хянагдаж байна. Хуулийн хугацааг сунгасан, хугацаа хэтрүүлж, шийдвэрлэсэн өргөдөл, гомдолгүй.

2.5. Мэдээллийн технологийн чиглэлээр:

2.5.1. Программ хангамж:

Монгол Улсын хилээр нэвтэрсэн гадаадын иргэний мэдээг ISM системээс шүүж, гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем (RNSF)-д 04 дүгээр сард шилжүүлсэн.

Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем (RNSF)-ээр дамжуулан Монгол Улсын хилээр 04 дүгээр сард нэвтэрсэн 5964 гадаадын иргэнд регистрийн дугаар олголоо.

Гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох систем (RNSF)-ийн нэмэлт хөгжүүлэлтийн хүрээнд Мобиком корпораци ХХК-тай гэрээ байгуулж, Юнител ХХК-д гэрээний төслийг хүргүүлэв.

Байгууллагын цахим хуудаст шинээр plugin нэмэх хөгжүүлэлтийг 04 дүгээр сарын 27-ны өдөр гүйцэтгэж, ажиллагаанд нэвтрүүлэн, “Хүний нөөц” талбарт 6 төрлийн мэдээлэл нэмж хавсралт файл байршуулсан.

Түүнчлэн Qray төлбөр тооцооны системийг eimmigratin.mn вэб сайттай холбох, нэвтрүүлэх туршилтын программ хангамжийн хөгжүүлэлтийг эхлүүллээ.

“Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” шинэ системийг эхлүүлсэнтэй холбогдуулан “Гэрэгэ системс” ХХК-тай нийт 3 удаагийн хурал зохион байгуулж, хэрэглэгчийн шаардлагыг эцсийн хувилбараар батлуулж, 04 дүгээр сарын 06-ны өдөр тус ХХК-д хүргүүлсэн.

Зөвлөгөө мэдээллийн үйлчилгээний утасны 1800-1882 дугаарыг CallPro системд шилжүүлэн, холбогдох техник хэрэгсэл, программ хангамжийн тохиргоог хийлээ.

2.6. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

2.6.1. Төсвийн хөрөнгийн зарцуулалт:

04 дүгээр сарын байдлаар өссөн дүнгээр 3,719.2 сая төгрөгийн санхүүжилт авч 2,219.8 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулан, холбогдох санхүүгийн баримт материалыг бүрдүүлж ажиллалаа.

Монгол улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа ЭСЯ, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын ӨМӨЗО-ны Хөх хотод суугаа ерөнхий консулын газарт ажиллаж байгаа виз, зөвшөөрлийн асуудал хариуцсан албан хаагчдын 04 дүгээр сарын санхүүжилт болох 29.2 сая төгрөгийг тухайн дипломат төлөөлөгчийн газруудад шилжүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны хөрөнгө оруулалтын төсвийн төслийн саналыг 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/728 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд www.shilendans.gov.mn сайтад 2021 оны төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын хяналт шалгалтын дүгнэлтийг байршууллаа. Түүнчлэн хуулийн дагуу уг сайтад төсөв

санхүүгийн 97 мэдээ, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 97 мэдээ, бусад 138 мэдээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

2.6.2. Орлого төвлөрүүлэлт:

Голомт банкны 1320000052 тоот төгрөгийн дансанд 04 дүгээр сарын 29-ний өдрийг дуустал хугацаанд (өссөн дүнгээр) 236.0 сая төгрөгийн орлого, 1305124929 тоот валютын дансанд 36288.36 ам.доллар буюу 108.8 сая төгрөг, орон нутгийн төсөвт орон нутаг дахь нэгжүүд нийт 403.0 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлээд байна.

2.6.3. Худалдан авалт:

Монгол Улсын 2022 оны төсвийн тодотголтой холбогдуулан хэмнэж болох зардлын саналыг 01/714 дүгээр, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нэгтгэлийг 07/688 дугаар, байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг шаардлагатай орон нутаг дахь газарт балансаас балансад шилжүүлэх тухай хүсэлтийг 01/812 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

131882 тусгай дугаарын мессеж илгээх үйлчилгээ, Юнивишн ХХК-ны IPTV үйлчилгээний гэрээг шинэчлэн байгуулах тухай хүсэлтийг 07/743 дугаар албан бичгээр холбогдох газарт хүргүүлж, 01/07-52, Corp/n22/555 дугаартай гэрээг шинээр байгуулав.

Баруун бүс дэх газрын барилгын ажлын захиалагчийн хяналтын гэрээ, зохиогчийн хяналтын гэрээг тус тус баталгаажуулсан.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсанаар “Саммит компьютер технологи” ХХК-аас 58 ширхэг техник хэрэгсэл, компьютер, “Батзүү” ХХК-аас 4 төрлийн 487 ширхэг нормын хувцсыг тус тус хүлээн авлаа.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор 2019 онд Хууль, зүйн туслалцааны төвд балансаас балансад шилжүүлсэн 2 ширхэг авто тээврийн хэрэгслийг байгууллагын бүртгэлээс хасуулах тухай 07/618 дугаар албан бичгийг Авто тээврийн үндэсний төвд хүргүүлсэн.

2.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын чиглэлээр:

2.7.1. Хяналт-шинжилгээ:

Гадаадын иргэний бүртгэл, хяналтын 03 дугаар сарын статистик мэдээг 04 дүгээр сарын 05-ны өдрийн 03/637 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, байгууллагын 03 дугаар сарын үйл ажиллагааны мэдээг мөн өдрийн 03/638, 03/639, 03/640 дүгээр албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлж ажилласан.

Байгууллагын 04 дүгээр сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд урьдчилсан хяналт шинжилгээ хийж, холбогдох санал дүгнэлтийг гаргалаа.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны мэдээг 04 дүгээр сарын 01-ээс 30-ны өдрүүдэд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт цахим хэлбэрээр нийт 21 удаа хүргүүлсэн.

2.7.2. Аудит, нийцлийн чиглэлээр:

Байгууллагын даргын 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх тухай” 01-10/04 дүгээр удирдамжаар төв болон орон нутаг дахь нэгжүүдийн холбогдох мэдээлэлд нэгдүгээр улирлын байдлаар дотоод аудит хийлээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын цахим хуудаст байршуулсан 03 дугаар сарын мэдээлэлд хяналт тавьж ажиллав.

“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийг 2020, 2021 онд хэрэгжүүлэх явцад зарцуулсан хөрөнгө, санхүүжилтийн болон үйл ажиллагааны тайлан, холбогдох баримт, мэдээллийг 04 дүгээр сарын 07-ны өдөр цахим хэлбэрээр Монгол Улсын Ерөнхий аудиторт хүргүүлээ.

2.8. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

“Монгол, Хятадын Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс”-д үүрэг гүйцэтгэх албан хаагчдын төлөвлөлтийг 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01/656 дугаар албан бичгээр Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчид, Шивээхүрэн хилийн боомтын өргөтгөл шинэчлэлийн хэсэгчилсэн төлөвлөгөөний саналыг мөн өдрийн 01/657 дугаар албан бичгээр Татах хүч ХХК-д, “Цагаан дэл уул” авто замын хилийн боомтын техник, эдийн засгийн үндэслэлд тусгах саналыг 19-ний өдрийн 01/742 дугаар албан бичгээр “Үлэмж” ХХК-д тус тус хүргүүлсэн.

Орон нутаг дахь нэгжүүд 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу хууль, эрх зүй болон болон эрүүл мэндийн чиглэлээр дотооддоо нийт 9 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна.

Мөн төрийн бусад байгууллагуудаас хууль эрх зүйн чиглэлээр зохион байгуулсан нийт 8 удаагийн сургалтад давхардсан тоогоор орон нутаг дахь нэгжийн 102 албан хаагч хамрагдсан.

Хойд бүс дэх газраас Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Архангай, Булган аймагт үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадын иргэнийг уригч аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөлд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, холбогдох журам болон байгууллагын цахим үйлчилгээг сурталчлан таниулах зорилгоор 04 дүгээр сарын 08-ны өдөр Дархан хотод уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, тус арга хэмжээнд 26 байгууллагын 31 удирдах албан тушаалтан, төлөөлөл оролцжээ.

Тайлант хугацаанд орон нутаг дахь нэгжийн дарга нараас 23 тушаал (үндсэн үйл ажиллагаатай холбоотой 7, хүний нөөцтэй холбоотой 16) баталсныг бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавин, биелэлтийг тооцон ажиллалаа.